



НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 07 сарын 03 өдөр

Дугаар 90

Улаанбаатар хот

Ашиг орлогын хуваарилалт тогтоох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.11 дэх заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.3 дахь заалт, 77 дугаар зүйлийн 77.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Нийслэлийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газруудын 2022 оны санхүүгийн тайлангийн цэвэр ашгаас 2023 онд нийслэлийн төсөвт төвлөрүүлэх ногдол ашгийн хувь, хэмжээг хавсралтаар баталсугай.

2. Төсөвт төвлөрүүлэхээр тооцсон нийт 1,862,529,950 (нэг тэрбум найман зуун жаран хоёр сая таван зуун хорин есөн мянга есөн зуун тавь) төгрөгийн ногдол ашгийг 2023 онд багтаан нийслэлийн төсөвт төвлөрүүлэх ажлыг зохион байгуулж ажиллахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч (Д.Сумъяабазар)-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Эдийн засаг, төсвийн хороо (М.Халиунбат)-д даалгасугай.

ДАРГА



Ж.БАТБАЯСГАЛАН

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2023 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 90.
дүгээр тогтоолын хавсралт

ОРОН НУТГИЙН ӨМЧИТ АЖ АХУЙН ТООЦООТОЙ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРУУДААС
НИЙСЛЭЛИЙН ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛЭХ НОГДОЛ АШИГ

№	Орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын нэрс	Ашиг, алдагдал		Ноогдол ашиг төвлөрүүлэх хувь хэмжээ	Ногдол ашгийн дүн	орлогын албат татвар 10%	Нийслэлийн төсөвт төвлөрүүлэх дүн
		Зорилт	Гүйцэтгэл				
1	"Ус сувгийн удирдах газар" ОНӨААТҮГ	(13,738,167,400)	1,880,668,800	30%	564,200,640	56,420,060	507,780,580
2	"Зорчигч тээврийн нэгтгэл" ОНҮААТҮГ	(5,731,111,000)	1,669,143,900	30%	500,743,170	50,074,320	450,668,850
3	"Зорчигч тээвэр гурав" ОНӨААТҮГ	(4,153,583,210)	1,822,954,200	30%	546,886,390	54,688,640	492,197,750
4	"Хөрөнгө оруулалтын газар" ОНӨААТҮГ	527,873,900	865,321,200	30%	259,596,360	25,959.64	233,636,720
5	"Өсвөр үе хүнс" ОНӨААТҮГ	34,744,200	223,419,260	30%	67,025,780	6,702,580	60,323,200
6	"Хүнс хангамж төв" ОНӨААТҮГ	53,972,300	167,369,300	30%	50,210,790	5,021,080	45,189,710
7	"Хот төлөвлөлт, судалгааны институт" ОНӨААТҮГ	141,325,600	151,413,400	30%	45,424,020	4,542,400	40,881,620
8	"Асгат" ОНӨААТҮГ	32,518,800	79,885,000	30%	23,965,500	2,396,550	21,568,950
9	"Улаанбаатар зам засвар, арчлалтын газар" ОНӨААТҮГ	154,416,000	38,083,600	30%	11,425,080	1,142,510	10,282,570
			6,898,259,080		2,069,477,720	206,947,770	1,862,529,950